

ДЭМБ-ЫН ТАМХИНЫ  
ХЯНАЛТЫН СУУРЬ  
КОНВЕНЦ

9 ба 10 дугаар зүйлийг  
хэрэгжүүлэх

ХЭСЭГЧИЛСЭН  
удирдамж

Тамхин бүтээгдэхүүний орц найрлага,  
түүнийг мэдээлэх журам



**F C T C**

WHO FRAMEWORK CONVENTION  
ON TOBACCO CONTROL

## ДЭМБ-ЫН ТАМХИНЫ ХЯНАЛТЫН СУУРЬ КОНВЕНЦ

9 ба 10 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хэсэгчилсэн  
удирдамж:

# “Тамхин бүтээгдэхүүний орц найрлага, түүнийг мэдээлэх журам”

Оролцогч талуудын Бага хурлын дөрөвдүгээр (шийдвэр дугаар FCTC/COP4(10))  
хуралдаанаар баталсан бөгөөд тавдугаар (шийдвэр FCTC/COP5(6)) ба  
долоодугаар (шийдвэр FCTC/COP7(14)) хуралдаанаар нэмэлт өөрчлөлт  
оруулсан.

Эх хувилбартай дараах хаягаар танилцана уу:

<https://fctc.who.int/publications/m/item/regulation-of-the-contents-of-tobacco-products-and-regulation-of-tobacco-product-disclosures>

## ДЭМБ-ЫН ТХСК-ИЙН 9 БА 10 ДУГААР ЗҮЙЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЭСЭГЧИЛСЭН УДИРДАМЖ<sup>1</sup>

### ТАМХИН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ОРЦ, НАЙРЛАГА, ТҮҮНИЙГ МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

#### 1. ЗОРИЛГО, ЗОРИЛТ, НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

##### 1.1 Зорилго

Энэхүү удирдамж нь ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенц (ДЭМБ-ын ТХСК)-ийн 9 ба 10 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь Оролцогч талуудад туслах зорилготой болно. Удирдамжид шинжлэх ухааны нотолгоо болон Оролцогч талуудын туршлагад тулгуурлан тамхин бүтээгдэхүүний орц найрлага, ялгаруулах бодис, түүнийг мэдээлэх асуудлыг журамлах замаар тамхины хяналтын бодлогыг бэхжүүлэх арга хэмжээг санал болгосон. Оролцогч талууд энэхүү удирдамжид санал болгосноос бусад арга хэмжээг нэмэлтээр хэрэгжүүлэх нь зүйтэй.<sup>2</sup>

Конвенцийн 9 дүгээр зүйлд тамхин бүтээгдэхүүний орц найрлага, ялгаруулах бодисыг тодорхойлох шинжилгээ, хэмжилт хийх талаар, 10 дугаар зүйлд орц найрлага, ялгаруулах бодисын талаарх мэдээллийг төрийн эрх бүхий байгууллага болон олон нийтэд мэдээлэх талаар зохицуулалтуудыг тусгасан байна. Энэхүү хоёр зүйл нь хоорондоо нягт уялдаатай тул тэдгээрийг хэрэгжүүлэх зөвлөмжийг нэг удирдамж болгон нэгтгэсэн болно.

##### 1.2 Зорилт

1.2.1 Тамхин бүтээгдэхүүний орц найрлага, ялгаруулах бодистой холбоотой асуудлыг журамлах нь

Тамхин бүтээгдэхүүнтэй холбоотой үр дүнтэй журам боловсруулахад нь Оролцогч талуудад дэмжлэг үзүүлэхэд энэхүү удирдамжийн нэг зорилт оршино. Тамхин бүтээгдэхүүнтэй холбоотой журам нь энэхүү бүтээгдэхүүний анхаарал татахуйц байдал, донтуулах чадвар буюу хорт чанарыг бууруулах замаар тамхины шалтгаант өвчлөл, цаг бус эндэгдлийг багасгахад хувь нэмэр оруулах боломжтой.

##### 1.2.1.1 Анхаарал татахуйц байдал

Тамхин бүтээгдэхүүний хэрэглээг хөхиүлэн дэмжихийн тулд түүнийг анхаарал татахуйц байдлаар үйлдвэрлэдэг. Нийгмийн эрүүл мэндийн байр сууринаас авч үзэхэд тамхин бүтээгдэхүүний анхаарал татахуйц байдлыг нэмэгдүүлдэг орц найрлага, тухайлбал амт оруулагчийг ашиглахыг зөвшөөрөх үндэслэл байхгүй. Тамхин бүтээгдэхүүний анхаарал татахуйц байдлыг багасгах бусад арга хэмжээний талаар ДЭМБ-ын ТХСК-ийн 11 ба 13 дугаар зүйлийг

<sup>1</sup> Оролцогч талуудын Бага хурлын 4 дүгээр хуралдаанаас 2010 онд баталж, 5 дугаар хуралдаанаас 2012 онд нэмэлт өөрчлөлт оруулсан байдлаар

<sup>2</sup> Эдгээр удирдамжид хөндсөн асуудлаар нэмэлт мэдээллийг ДЭМБ-ын ТХСК-ийн вэб сайтаас (<https://fctc.who.int/>) авч болно.

хэрэгжүүлэх удирдамжид тусгах болно.<sup>3</sup>

ДЭМБ-ын ТХСК-ийн удиртгал хэсэгт тамхин бүтээгдэхүүн хортой бөгөөд донтуулах үйлчилгээтэй гэдгийг цохон тэмдэглэсэн байна. Тамхин бүтээгдэхүүний орц найрлагаас зарим бодисыг хасах, агуурамжийг бууруулах нь эдгээр бүтээгдэхүүнийг хүний эрүүл мэндэд хор аюул багатай болгож байгаа хэрэг биш.

#### 1.2.1.2 Донтуулах чанар

Тамхин бүтээгдэхүүн донтуулах чанартай болох нь нэгэнт батлагдсан юм. ДЭМБ-ын ТХСК-ийн удиртгал хэсэгт тамхин бүтээгдэхүүн донтуулах үйлчилгээтэй болохыг тодорхой зааж, хүлээн зөвшөөрчээ. Улмаар Конвенцийн 5.2 дугаар зүйлд Оролцогч талууд “тамхины хэрэглээ, никотины хамаарал, тамхины утаанд өртөх явдлаас сэргийлэх, бууруулах бодлого боловсруулахад бусад Оролцогч талуудтай хамтран ажиллах, үр дүнтэй хууль эрх зүйн, захиргааны ба /буюу бусад арга хэмжээ хэрэгжүүлэх” шаардлагатай гэсэн байна.

Тамхин бүтээгдэхүүний дан орц найрлага эсхүл орц найрлага болон ялгаруулах бодисын агууламжийг зохицуулах замаар тамхин бүтээгдэхүүнийг өөрчлөх нь никотины хамаарал/тамхинд донтох явдлаас сэргийлэхэд нөлөөлдөг байна. Мөн тамхинд донтогсдод тамхинаас гарахад нь тус дөхөм болдог.

Тамхин бүтээгдэхүүний дан орц найрлага эсхүл орц найрлага болон ялгаруулах бодисын агууламжийг зохицуулснаар донтуулах чанарыг бууруулах нь эдгээр бүтээгдэхүүнийг хүний эрүүл мэндэд хор аюул багатай болгож байгаа хэрэг биш юм.

#### 1.2.1.3 Хорт чанар

(Энэ хэсгийг албаар хоосон орхисон бөгөөд удирдамжийг нь дараа санал болгоно.)

#### 1.2.2 Төрийн эрх бүхий байгууллагад мэдээлэх нь

Конвенцийн 10 дугаар зүйлд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагуудад мэдээлэл өгөхийг шаардах нь тамхин бүтээгдэхүүний орц найрлага, ялгаруулах бодис, хорт болон донтуулах чанарын талаар холбогдох мэдээллийг үйлдвэрлэгчид болон импортлогч нараас авах үндсэн зорилготой. Энэхүү мэдээлэл нь бодлого, үйл ажиллагаа, журам боловсруулах, хэрэгжүүлэх, тамхин бүтээгдэхүүний орц найрлага, ялгаруулах бодисын дүн шинжилгээ хийх, зах зээлийн хандлагыг хянах, тамхи үйлдвэрлэгчийн мэдэгдлийг үнэлэх зэрэгт шаардлагатай юм.

#### 1.2.3 Олон нийтэд мэдээлэх нь

Конвенцийн 10 дугаар зүйлд заасны дагуу тамхин бүтээгдэхүүний орц найрлага, ялгаруулах бодисын талаар олон нийтэд мэдээлэх нь тамхины хэрэглээ, тамхины утаанд өртсөнтэй холбоотой хүний эрүүл мэндэд үзүүлэх

<sup>3</sup> Нэмэлт мэдээллийг дараах эх сурвалжаас харна уу: ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь Конвенц: хэрэгжүүлэх удирдамж. 5.3 дугаар зүйл, 8 дугаар зүйл, 11 дүгээр зүйл, 13 дугаар зүйл. Женев, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, 2009.

нөлөө, донтуулах чанар, үхлийн аюулын талаар олон нийтэд мэдээлэл хүргэх үндсэн зорилготой.

Энэхүү мэдээлэл нь холбогдох бодлого, үйл ажиллагаа, журам боловсруулах, хэрэгжүүлэхэд олон нийтийн зүгээс хувь нэмрээ оруулахад нь мөн тус дөхөм болно.

### 1.3 Нэр томъёоны тайлбар

- **“Анхаарал татахуйц байдал”** гэдэг нь амт, үнэр болон мэдрэхүйн бусад шинж чанар, хэрэглэхэд хялбар байдал, тунг тохируулах уян хатан систем, үнэ, нэр хүнд буюу имидж, эрсдэл ба үр өгөөжийн талаарх түгээмэл ойлголт зэрэг бүтээгдэхүүний хэрэглээг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн шинж чанар, хүчин зүйл юм.<sup>4</sup>
- **“Арвижуулсан тамхи”** гэж хуурай мөс зэрэг орчныг хурдан ууршуулах замаар эзлэхүүнийг нэмэгдүүлсэн тамхи юм.
- **“Дахин биежүүлсэн тамхи”** гэдэг нь ихэнхдээ тамхинаас тогтсон цаастай төстэй материал юм.
- **“Дизайны онцлог”** гэдэг нь тамхин бүтээгдэхүүний орц найрлага, ялгаруулах бодисыг тодорхойлох шинжилгээ, хэмжилт хийхэд шууд нөлөөлдөг тухайн бүтээгдэхүүний дизайны шинж чанар юм. Тухайлбал, янжуур тамхины шүүлтүүрийн эргэн тойрны агааржуулалтын нүх нь никотины агууламжийг тоног төхөөрөмжөөр хэмжихэд нөлөөлж, бодит агууламжаас бага үзүүлэлт гарахад нөлөөлдөг байна.
- **“Донтуулах чанар”** буюу хамаарал үүсгэх чадвар гэдэг нь бодис буюу бүтээгдэхүүний өөрөөс хараат болгох эмзүйн чадвар юм. Донтуулах чанар нь тун, шингээлтийн хурд, бодисын солилцоо, физик болон химийн шинж чанар зэрэг тамхин бүтээгдэхүүний онцлогоос хамаардаг нарийн нийлмэл үйл явц байдаг. “Донтуулах чанар” болон “никотины хамаарал” зэрэг ойлголт нь хоорондоо нягт уялдаатай боловч агуулга нь ялгаатай юм.<sup>5</sup>
- **“Орц найрлага”** гэдэг нь боловсруулсан тамхины хувьд “найрлага дахь бодис”, тамхин бүтээгдэхүүний хувьд “бүрэлдэхүүн хэсэг” гэсэн утгатай ойлголт юм. :
  - **“Бүрэлдэхүүн хэсэг”** гэдэгт тамхи, бусад бүтээгдэхүүн (цаас, шүүлтүүр г.м), үүнд мөн эдгээр бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд ашигласан материал, нэмэлт, үйлдвэрлэлийн туслах бодис, тамхин дахь үлдэгдэл бодис (хадгалалт, боловсруулалттай холбоотой), сав, баглаа, боодлоос тамхи руу нэвчсэн бодис (бохирдуулагч нь бүрэлдэхүүн хэсэг биш) хамаарна.
  - **“Найрлага дахь бодис”**  
(Энэ хэсгийг албаар хоосон орхисон бөгөөд удирдамжийг нь дараа санал болгоно.)

<sup>4</sup> ДЭМБ. Тамхин бүтээгдэхүүний зохицуулалтыг шинжлэх ухааны үндэслэл: ДЭМБ-ын судалгааны багийн тайлан. ДЭМБ-ын мэргэжлийн тайлан, цуврал 945. Женев, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, 2007.

<sup>5</sup> “Никотины хамаарал” гэсэн ойлголтыг ТХСК-ийн 5 ба 22 дугаар зүйлд, харин “тамхинд донтох” гэсэн ойлголтыг 14 дүгээр зүйлд ашигласан байна. ДЭМБ-ын ТХСК-ийн 14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх удирдамжийн “Нэр томъёоны тайлбар” хэсэгт “тамхинд донтох” нэр томъёоны тодорхойлолтыг толилуулсан болно.

- **“Тамхин бүтээгдэхүүн”** гэдэг нь ДЭМБ-ын ТХСК-ийн 1 дүгээр зүйлд тодорхойлсноор “татах, сорох, зажлах, хамраар тамхилах зориулалт бүхий бүхэлдээ буюу хэсэгчлэн тамхины навчны түүхий эдээр хийсэн бүтээгдэхүүн” юм.
- **“Тамхи үйлдвэрлэгч”** гэдэг нь ДЭМБ-ын ТХСК-ийн 1 дүгээр зүйлд тодорхойлсноор “тамхины үйлдвэрлэл эрхлэгчид, бөөний худалдааны дистрибьютер, тамхин бүтээгдэхүүний импортлогч нар” юм.
- **“Ялгаруулах бодис”** гэдэг нь тамхин бүтээгдэхүүнийг зориулалтынх нь дагуу хэрэглэхэд ялгардаг бодис юм. Тухайлбал, янжуур болон бусад утаат тамхин бүтээгдэхүүний хувьд тамхины утаан дахь бодис нь ялгаруулах бодис юм. Утаагүй тамхин бүтээгдэхүүний хувьд зажлах, сорох явцад ялгарч буй бодис, хамрын тамхины хувьд тамхилах үед ялгарч буй бодис юм.

## **2. ПРАКТИК АСУУДАЛ**

### **2.1 9 дүгээр зүйлд заасан арга хэмжээг батлан хэрэгжүүлэх нь**

ДЭМБ-ын ТХСК-ийн 9 дүгээр зүйлд заасны дагуу Оролцогч талууд үндэсний эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бол тамхин бүтээгдэхүүний орц найрлага, ялгаруулах бодисыг тодорхойлох, хэмжих болон эдгээрийг журамлах хууль эрх зүйн, захиргааны буюу бусад үр дүнтэй арга хэмжээг батлан хэрэгжүүлэх ёстой.

Оролцогч талууд тамхины хяналтын асуудал хариуцсан эрх бүхий байгууллагад дээрх арга хэмжээг батлан хэрэгжүүлэх эрх мэдлийг, үгүйдээ үүнд оролцох боломжийг олгох нь зүйтэй.

### **2.2 10 дугаар зүйлд заасан арга хэмжээг батлан хэрэгжүүлэх нь**

ДЭМБ-ын ТХСК-ийн 10 дугаар зүйлд заасны дагуу Оролцогч талууд үндэсний хууль тогтоомждоо нийцүүлэн тамхи үйлдвэрлэгчид болон импортлогчдын зүгээс тамхин бүтээгдэхүүний орц найрлага, ялгаруулах бодисын талаарх мэдээллийг төрийн эрх бүхий байгууллагуудад өгөх, тамхин бүтээгдэхүүний найрлага дахь болон ялгаруулах хорт бодисын талаарх мэдээллийг олон нийтэд өгөх эрх зүйн, захиргааны буюу бусад үр дүнтэй арга хэмжээг батлан хэрэгжүүлэх ёстой.

Оролцогч талууд тамхины хяналтын асуудал хариуцсан эрх бүхий байгууллагад дээрх арга хэмжээг батлан хэрэгжүүлэх эрх мэдлийг, үгүйдээ үүнд оролцох боломжийг олгох нь зүйтэй.

### **2.3 Санхүүжилт**

Тамхин бүтээгдэхүүний асуудлыг үр дүнтэй журамлаж, түүнийг хэрэгжүүлэхэд Оролцогч талууд мэдэгдэхүйц хэмжээний санхүүжилтийг хуваарилах шаардлагатай. Улсын төсөвт үзүүлэх ачааллыг бууруулахын тулд Оролцогч талууд эдгээр зардлыг тамхи үйлдвэрлэгчид болон тамхины худалдаа эрхлэгчдэд үүрүүлэх арга замыг харгалзан үзэх нь зүйтэй. Тамхин бүтээгдэхүүний зохицуулалтын арга хэмжээг санхүүжүүлэх олон арга зам байдаг.

Оролцогч талуудад жишээ болгон дараах жагсаалтыг танилцуулж байна. Үүнд:

- Тамхины тусгайлсан татвар;
- Тамхины үйлдвэрлэл эрхлэх ба/буюу импортын тусгай зөвшөөрлийн төлбөр;
- Тамхин бүтээгдэхүүний бүртгэлийн төлбөр;
- Тамхины дистрибьютер ба/буюу жижиглэнгийн худалдаа эрхлэгчдэд тусгай зөвшөөрөл олгох;
- Журам зөрчсөн тамхи үйлдвэрлэгчид болон жижиглэнгийн худалдаа эрхлэгчдэд торгууль ногдуулах;
- Жил тутам хийх тамхины тандалтын төлбөр (тамхи үйлдвэрлэгчид болон жижиглэнгийн худалдаа эрхлэгчдээс авах).

Тамхин бүтээгдэхүүний зохицуулалтын арга хэмжээг санхүүжүүлэх аргуудын тайлбар бүхий жишээг Хавсралт 1-ээс харна уу.

## **2.4 Орц найрлагын талаар мэдээлэл өгөхөд ашиглах лаборатори**

Төрийн эрх бүхий байгууллагуудад тамхин бүтээгдэхүүний орц найрлагын талаар мэдээлэл өгөх лабораториуд хүлээн зөвшөөрөгдсөн магадлан итгэмжлэлийн байгууллагаар Стандартчиллын олон улсын байгууллагын ISO 17025 стандарт (Шинжилгээ, тохиргооны лабораторийн ур чадварт тавих ерөнхий шаардлага)-ын дагуу магадлан итгэмжлэгдсэн байх ёстой. Магадлан итгэмжлэлд дор хаяж энэхүү удирдамжид заасан аргуудыг ашигласан байвал зохино.

## **2.5 Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянахад ашиглах лаборатори**

Оролцогч талууд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянахад улсын лаборатори эсхүл тамхи үйлдвэрлэгчийн шууд буюу дам хяналтад байдаггүй хараат бус лабораторийг ашиглах шаардлагатай. Эдгээр нь өмнөх хэсэгт заасанчлан магадлан итгэмжлэгдсэн байх ёстой. Оролцогч талууд мөн бусад улсад байршилтай улсын буюу хараат бус лабораторийг ашиглаж болно.

## **2.6 Төрийн эрх бүхий байгууллагад мэдээлэл өгөхтэй холбоотой нууцлалын асуудал**

Тамхи үйлдвэрлэгчдийн зүгээс тамхин бүтээгдэхүүний орц найрлага, ялгаруулах бодисын талаарх мэдээллийг нууц гэдэг үндэслэлээр төрийн эрх бүхий байгууллагад өгөхөөс татгалзах явдлыг Оролцогч талууд хүлээн зөвшөөрч болохгүй. Харин тамхи үйлдвэрлэгчид болон үйлдвэрлэгч нарын зүгээс нууц гэсэн мэдээллийг цуглуулахдаа төрийн эрх бүхий байгууллагууд үндэсний хууль тогтоомжийн дагуу холбогдох дүрэм журмыг мөрдөж, энэхүү мэдээллийг зүй бусаар ашиглах, бусдад тараахаас сэргийлэх арга хэмжээ авна.<sup>6</sup>

<sup>6</sup> Энэхүү мэдээллийг олон нийтэд мэдээлэх талаарх зөвлөмжийг дараа дараагийн удирдамжуудад тодорхой тусгахаар орхисон болно.

## **2.7 Олон нийтэд мэдээлэл өгөхтэй холбоотой нууцлалын асуудал**

Оролцогч талууд тамхин бүтээгдэхүүний найрлага дахь болон ялгаруулах бодисын талаар олон нийтэд хэрэгтэй мэдээллийг өгөхөд анхаарах нь зүйтэй. Оролцогч талууд тамхин бүтээгдэхүүний найрлага дахь хорт бодис, ялгаруулах бодисын талаар ямар мэдээллийг олон нийтэд олон нийтэд ил болгохгүй байхыг үндэсний хууль тогтоомждоо нийцүүлэн шийдвэрлэж болно.

## **2.8 Иргэний нийгэм**

Тамхин бүтээгдэхүүний орц найрлага ба ялгаруулах бодист тавих шаардлага, эдгээр бодисын талаар мэдээлэх асуудлыг зохицуулах тал дээр олон нийтийн сонор сэрэмжийг дээшлүүлэх, дэмжлэгийг олж авахад иргэний нийгэм чухал үүрэгтэй. Иргэний нийгмийг идэвхтэй түнш болгох нь зүйтэй.

## **3. АРГА ХЭМЖЭЭ**

### **3.1 Орц найрлага**

#### **3.1.1 Бүрэлдэхүүн хэсэг (Мэдээлэх нь)**

Тамхи үйлдвэрлэгчид болон импортлогчдыг өөрийн бүтээгдэхүүний бүрэлдэхүүн хэсгийн талаар төрийн эрх бүхий байгууллагуудад мэдээлдэг болгох зорилгоор Оролцогч талуудын зүгээс хэрэгжүүлэх арга хэмжээг энэ хэсэгт танилцуулсан болно.

##### **3.1.1.1 Суурь мэдээлэл**

Тамхи үйлдвэрлэгч, импортлогч нарт өөрийн бүтээгдэхүүний бүрэлдэхүүн хэсгийн талаар төрийн эрх бүхий байгууллагуудад мэдээлэх шаардлагыг тавьснаар тамхин бүтээгдэхүүний орц найрлагын талаар үнэтэй мэдээлэл олж авч, улмаар үр дүнтэй, бүтээгдэхүүн тус бүрт нийцсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжтой юм.

##### **3.1.1.2 Зөвлөмж**

- (i) Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгч, импортлогч нарт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд ашигласан бүрэлдэхүүн хэсгүүдийн талаарх мэдээллийг тодорхой давтамжтайгаар, бүтээгдэхүүний төрөл болон брэнд тус бүрээр төрийн эрх бүхий байгууллагуудад гаргаж өгч байх шаардлага тавина. Бүрэлдэхүүн хэсгийн талаарх мэдээллийг нэгдсэн жагсаалт хэлбэрээр гаргахын оронд брэнд тус бүрээр стандарт маягтын дагуу гаргуулж авах нь төрийн эрх бүхий байгууллагуудад бүтээгдэхүүний орц найрлагын өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх, зах зээл дээрх өөрчлөлтийг хянах боломж олгоно.
- (ii) Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгч, импортлогч нарт бүтээгдэхүүн тус бүрийг үйлдвэрлэхэд ашигласан бүрэлдэхүүн хэсэг, тэдгээрийн нэгж бүтээгдэхүүн дэх агууламж, тамхины шүүлтүүр, цаас, цавуу зэрэг бусад бүрэлдэхүүн дэх бодисын агууламжийн талаарх мэдээллийг брэнд тус



бүрээр төрийн эрх бүхий байгууллагуудад гаргаж өгч байх шаардлага тавина. Оролцогч талууд бүрэлдэхүүн хэсгийн категориор гаргасан агууламжийн дээд хэмжээ буюу нийт хэмжээ зэрэг зөвхөн нэгтгэсэн тоо мэдээг хүлээж авч болохгүй. Эс бөгөөс нарийвчилсан дүн шинжилгээ хийх боломжгүй болно.

- (iii) Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгч, импортлогч нарт ашигласан тамхины навчны шинж чанарын талаарх мэдээллийг гаргаж өгөх шаардлага тавина. Тухайлбал:
  - i. Тухайн тамхин бүтээгдэхүүнд ашигласан тамхины навчны төрөл (ж.нь, Виржини, Барлей, Дорнын) болон төрөл тус бүрийн эзлэх хувь;
  - ii. Дахин биежүүлсэн тамхины эзлэх хувь;
  - iii. Арвижуулсан тамхины эзлэх хувь;
- (iv) Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгч, импортлогч нарт бүтээгдэхүүний бүрэлдэхүүн хэсэгт өөрчлөлт орсон тохиолдолд төрийн эрх бүхий байгууллагуудад мэдээлж байх шаардлага тавина;
- (v) Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгч, импортлогч нарт тамхин бүтээгдэхүүнд тодорхой бүрэлдэхүүн хэсгийг<sup>7</sup> оруулах болсон шалтгаан болон бусад холбогдох мэдээллийг гаргаж өгөх шаардлага тавина;
- (vi) Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгч нарт бүрэлдэхүүн хэсэг тус бүрийг нийлүүлэгчийн нэр, хаяг, холбоо барих бусад мэдээллийг гаргаж өгөх шаардлага тавина. Энэ нь шаардлагатай бол нийлүүлэгчээс шууд мэдээлэл авах, хууль тогтоомжийн мөрдөлтөд хяналт тавихад тус дөхөм болно.

### 3.1.2 Бүрэлдэхүүн хэсэг (Журамлах нь)

Энэ хэсэгт Оролцогч талууд бүрэлдэхүүн хэсэгтэй холбоотой асуудлыг журамлахын тулд хэрэглэх арга хэмжээг тоймлосон болно.

Оролцогч талууд эдгээр арга хэмжээг үндэсний хууль тогтоомждоо нийцүүлэн өөрийн орны нөхцөл байдал, тэргүүлэх чиглэлийг харгалзан хэрэгжүүлнэ.

Оролцогч талууд тамхин бүтээгдэхүүний бүрэлдэхүүн хэсэгтэй холбоотой шинэ арга хэмжээ хэрэгжүүлэхийн тулд шинжлэх ухааны нотолгоо, бусад нотолгоо болон бусад орны туршлагыг харгалзан үзэж, хамгийн үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорих шаардлагатай.

#### 3.1.2.1 Суурь мэдээлэл

Тамхин бүтээгдэхүүний анхаарал татахуйц байдлыг бууруулах зорилгоор бүрэлдэхүүн хэсгийн асуудлыг журамлах нь тамхины хэрэглээ, хамаарлыг багасгахад нөлөөлж болно. ДЭМБ-ын ТХСК-ийн удиртгал хэсэгт “янжуур тамхи болон тамхи агуулсан бусад бүтээгдэхүүн нь донтуулах зорилгоор бүтээгдсэн” болохыг хүлээн зөвшөөрсөн байна.

Журамлах арга хэмжээг төлөвлөхдөө тамхин бүтээгдэхүүний анхаарал татахуйц байдал болон түүний донтолтод үзүүлэх нөлөөг харгалзан үзэх

<sup>7</sup> Тухайлбал, цавуу, шаталтыг хувиргагч, донтуулах чанарыг нэмэгдүүлэх бодис, амт оруулагч, чийг баригч бодис, уян хатан чанарыг сайжруулах бодис, ороох цаас, утааг нэмэгдүүлэгч бодис, өнгө оруулагч бодис.

шаардлагатай. ДЭМБ-ын ТХСК-ийн тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны тухай 13 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамжид тамхин бүтээгдэхүүний анхаарал татахуйц байдлыг нэмэгдүүлж болох аль болох олон шинж чанарт хязгаарлалт тавихыг зөвлөмж болгосон байна. Тухайлбал, тамхи ороох өнгө өнгийн цаас, таатай үнэр оруулагч ашиглахыг хориглохыг зөвлөдөг. Энэ хэсэгт мөн тамхи татаж эхлэх сэдлийг бууруулах арга хэмжээний талаар толилуулсан болно.

### 3.1.2.2 Тамхин бүтээгдэхүүн

#### (i) Мэдрэхүй таатай болгохоор ашигладаг бүрэлдэхүүн хэсэг

Тамхины утааны эхүүн, хурц үнэр нь тамхи татаж үзэх сонирхлыг бууруулдаг чухал саад болдог. Тамхи үйлдвэрлэгчдийн баримт тэмдэглэлээс харахад эдгээр таагүй шинж чанарыг багасгахын тулд нилээд хүчин чармайлт гаргасан нь тодорхой байдаг. Эхүүн үнэрийг дарахын тулд янз бүрийн бүрэлдэхүүн хэсэг нэмэх, цочроох үйлчилгээтэй бодисыг зайлуулах, цочроох үйлчилгээг мэдрэхүйн бусад үйлчилгээтэй тэнцвэржүүлэх, тусгай бодис нэмэх замаар тамхин бүтээгдэхүүнээс ялгарах бодисын химийн шинж чанарыг өөрчлөх зэрэг олон аргыг ашигладаг байна.

Зарим тамхин бүтээгдэхүүнд сахар, амт оруулагч нэмдэг. Сахарын агууламж өндөр байх нь тамхин бүтээгдэхүүнийг хэрэглэгчийн мэдрэхүйд таатай болгодог байна. Тухайлбал, тамхин бүтээгдэхүүнд глюкоз, сахарын сироп, зөгийн бал, сорбитол зэрэг амт оруулагчийг ашигладаг.

Тамхины утааны хурц үнэрийг амт оруулагчаар далдлах нь тамхийг үргэлжлүүлэн хэрэглэхэд нөлөөлдөг. Амт оруулагч бодисын жишээ болгон бензальдегид, мальтоз, гаа, ванелин зэргийг дурдаж болно.

Тамхин бүтээгдэхүүний мэдрэхүйд таатай байдлыг нэмэгдүүлэхийн тулд мөн цагаан гаа, гааны ургамал зэрэг хоолны амтлагч, ургамал зэргийг ашиглаж болдог.

#### *Зөвлөмж:*

Оролцогч талууд тамхин бүтээгдэхүүний мэдрэхүйд таатай байдлыг нэмэгдүүлдэг бүрэлдэхүүн хэсгийг ашиглахыг хориглох буюу хязгаарлах асуудлыг журамлах шаардлагатай.

Тамхин бүтээгдэхүүний үйлдвэрлэлд зайлшгүй шаардлагатай бөгөөд анхаарал татахуйц байдлыг сайжруулахад нөлөөлдөггүй бүрэлдэхүүн хэсгийн хэрэглээг үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн журамлах нь зүйтэй.

#### (ii) Өнгө оруулагч бүрэлдэхүүн хэсэг

Тамхин бүтээгдэхүүний анхаарал татахуйц байдлыг нэмэгдүүлэх зорилгоор бүрэлдэхүүн хэсгүүдэд нь өнгө оруулагч нэмж болдог. Зарим улсад анхаарал татахуйц өнгөтэй (ж.нь, ягаан, хар, хөх) янжуур тамхийг зах зээлд нийлүүлж ирсэн. Өнгө оруулах зорилгоор бэх (ж.нь, соруулын цаасыг модны холтос шиг хээтэй болгох) болон будагч бодис (ж.нь, шүүлтүүрэнд титаны давхар исэл ашиглах) ашиглаж болно.

#### *Зөвлөмж:*

Оролцогч талууд тамхин бүтээгдэхүүнд өнгө оруулах шинж чанартай бүрэлдэхүүн хэсэг ашиглахыг хориглох буюу хязгаарлах шаардлагатай. Харин

татвар төлсөн тухай тэмдэглэгээ буюу эрүүл мэндийн анхааруулгад өнгө оруулагч бодис ашиглахыг зөвшөөрөх нь зүйтэй.

- (iii) Бүтээгдэхүүн эрүүл мэндэд сайн гэсэн сэтгэгдэл төрүүлэх зорилгоор ашигладаг бүрэлдэхүүн хэсэг

Тамхин бүтээгдэхүүн эрүүл мэндэд сайн эсхүл эрүүл мэндэд үзүүлэх хор хөнөөл нь бага гэсэн сэтгэгдэл төрүүлэх зорилгоор төрөл бүрийн бүрэлдэхүүн хэсгийг ашигладаг. Тухайлбал, С, Е зэрэг аминдэм, жимс, хүнсний ногоо (буюу жимсний шүүс зэрэг тэдгээрийг боловсруулж гаргаж авсан бүтээгдэхүүн), цистеин, триптофан зэрэг аминхүчил, омега-3, омега-6 зэрэг өөхний хүчил.

*Зөвлөмж:*

Оролцогч талууд тамхин бүтээгдэхүүн эрүүл мэндэд сайн гэсэн сэтгэгдэл төрүүлж болохуйц бүрэлдэхүүн хэсгийг хориглох шаардлагатай.

- (iv) Энерги, амьдралын эрч хүчтэй холбоотой бүрэлдэхүүн хэсэг

Зарим улс орнуудад залуучуудын өргөнөөр хэрэглэдэг энергийн ундааг соргог байдал, биеийн хүчийг сайжруулдаг гэж үздэг. Ийм ундаанд кофеин, гуаран, таурин, глюкоуронолактон зэрэг сэргээх үйлчилгээтэй бодис ашигладаг байна. Тамхи үйлдвэрлэгчдийн баримт сэлт, патент авахаар бүрдүүлсэн материалаас үзэхэд эдгээрийн зарим (кофеин, таурин)-ыг тамхин бүтээгдэхүүнд ашиглах оролдлого хийгдэж байв.

*Зөвлөмж:*

Оролцогч талууд тамхин бүтээгдэхүүнд сэргээгч бодис зэрэг энерги, амьдралын эрч хүчтэй холбоотой бүрэлдэхүүн хэсгийг ашиглахыг хориглох шаардлагатай.

### 3.1.3 Орц найрлага (Төрийн эрх бүхий байгууллагад мэдээлэх нь)

Тамхи үйлдвэрлэгчид болон импортлогчдыг өөрийн бүтээгдэхүүний орц найрлагын талаар төрийн эрх бүхий байгууллагуудад мэдээлдэг болгох зорилгоор Оролцогч талуудын зүгээс хэрэгжүүлэх арга хэмжээг энэ хэсэгт танилцуулсан болно.

#### 3.1.3.1 Суурь мэдээлэл

Тамхин бүтээгдэхүүнд хорт болон донтуулах бодис ихээр агуулагддаг тул тамхины орц найрлагын талаар мэдээлэл авах нь төрийн эрх бүхий байгууллагуудад тамхин бүтээгдэхүүний зах зээлийн мөн чанарыг ойлгох боломжийг олгодог байна. Эрх бүхий байгууллагууд тамхин бүтээгдэхүүний анхаарал татахуйц байдал, донтуулах буюу хорт чанарыг харгалзан бодлого, журам боловсруулахад энэхүү мэдээллийг ашиглах боломжтой юм. Тухайлбал, тамхины донтуулах чанарыг тодорхойлдог гол бодис нь никотин байдаг тул Оролцогч талууд дотоодын зах зээл дээр борлуулагдаж буй тамхин бүтээгдэхүүн дэх никотины хэмжээний талаар мэдээлэл авах шаардлагатай.

Ийм төрлийн мэдээллийг олж авах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагууд ДЭМБ-аас боловсруулсан тамхин бүтээгдэхүүний орц найрлагыг тодорхойлох, хэмжих лабораторийн шинжилгээний аргуудыг ашиглах

шаардлага тавьж болно.<sup>8</sup> ДЭМБ-ын тамхин бүтээгдэхүүний зохицуулалтын судалгааны багаас ТХСК-ийн 9 ба 10 дугаар зүйлийн дагуу нэн түрүүн журамлах шаардлагатай тамхин бүтээгдэхүүний орц найрлага дахь хорт болон ялгаруулах бодисын бүрэн бус жагсаалтыг гаргасан.<sup>9</sup> Эдгээр шинжилгээний аргуудыг олон төрлийн лабораториудад ашиглах боломжтой. Үүнээс гадна янз бүрийн төрийн болон олон улсын байгууллагуудын боловсруулсан аргууд байдаг.

### 3.1.3.2 Зөвлөмж

- (i) Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгч, импортлогч нарт бүтээгдэхүүний орц найрлагын талаарх мэдээллийг тодорхой давтамжтайгаар, бүтээгдэхүүний төрөл болон брэнд тус бүрээр төрийн эрх бүхий байгууллагуудад гаргаж өгч байх шаардлага тавина.
- (ii) Орц найрлагыг тодорхойлох, хэмжих шинжилгээ хийх шаардлага тавихдаа Оролцогч талууд лабораториудад Оролцогч талуудын харилцан зөвшилцсөн стандарт эсхүл ДЭМБ-ын Тамхины лабораторийн сүлжээний зөвлөмжийн алийг мөрдөхийг тодорхой болгох нь зүйтэй. Никотины хувьд лабораторийн шинжилгээнд ДЭМБ-ын Тамхины лабораторийн сүлжээний албан ёсны аргачлал болох “янжуур тамхины шүүлтүүр дээр никотиныг тодорхойлох стандарт удирдамж 04”-ыг ашиглахыг Оролцогч талууд тодорхой заах нь зүйтэй.<sup>10</sup>
- (iii) Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгч, импортлогч бүрээс бүтээгдэхүүн нь шинжилгээнд хамрагдсан тухай лабораторийн тайлан, шинжилгээний хариу зэргийг төрийн эрх бүхий байгууллагад гаргаж өгөхийг шаардана. Түүнчлэн шинжилгээ хийсэн лаборатори нь ДЭМБ-ын Тамхины лабораторийн сүлжээний гишүүн буюу түүгээр магадлан итгэмжлэгдсэн, эсхүл Оролцогч талын эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан гэх нотолгоог шаардаж авна.

### 3.1.4 Найрлага дахь бодис (Журамлах нь)

(Энэхүү хэсгийг дараа дараагийн удирдамжуудад тодорхой тусгахаар хоосон орхисон болно.)

## 3.2 Ялгаруулах бодис

(Энэхүү хэсгийг дараа дараагийн удирдамжуудад тодорхой тусгахаар хоосон орхисон болно.)

## 3.3 Бүтээгдэхүүний шинж чанар

### 3.3.1 Мэдээлэх нь

<sup>8</sup> ДЭМБ-ын аргуудын жагсаалтыг <https://www.who.int/publications/i/item/tobacco-product-regulation-building-laboratory-testing-capacity> вэб сайтаас харна уу.

<sup>9</sup> Жагсаалтыг дараах эх сурвалжаас харна уу: ДЭМБ-ын мэргэжлийн тайлан, цуврал 989, ДЭМБ-ын Тамхин бүтээгдэхүүний зохицуулалтын судалгааны баг: тамхин бүтээгдэхүүний зохицуулалтын шинжлэх ухааны үндэслэл. <http://apps.who.int/iris/bitstream/10665/161512/1/9789241209892.pdf?ua=1&ua=1>

<sup>10</sup> <https://untobaccocontrol.org/impldb/article-10/>

Энэ хэсэгт Оролцогч талууд дизайны онцлог зэрэг бүтээгдэхүүний шинж чанарын талаарх мэдээллийг ил болгохыг тамхи үйлдвэрлэгчид, импортлогчдоос шаардахын тулд хэрэгжүүлэх арга хэмжээг тоймлосон болно.

### 3.3.1.1 Суурь мэдээлэл

Дизайны онцлог зэрэг бүтээгдэхүүний шинж чанарын талаар мэдээлэл цуглуулснаар Оролцогч талууд эдгээр шинж чанар нь тамхинаас ялгарах бодисын түвшинд хэрхэн нөлөөлж байгааг ойлгох, хэмжилтийн үр дүнг зөвөөр тайлбарлах, гол нь тамхины дизайн хэрхэн өөрчлөгдөж байгаа талаар цаг алдалгүй мэдэх боломжтой болно.

Энэхүү мэдээг борлуулалтын тоо мэдээтэй нэгтгэснээр Оролцогч талууд зах зээлийн хандлагад дүн шинжилгээ хийх боломжтой юм.

### 3.3.1.2 Зөвлөмж

- (i) Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгч, импортлогч нарт дизайны онцлог зэрэг бүтээгдэхүүний шинж чанарын талаарх мэдээлэл, шаардлагатай бол шинжилгээний хариу зэргийг тодорхой давтамжтайгаар төрийн эрх бүхий байгууллагуудад гаргаж өгч байх шаардлага тавина.
- (ii) Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгчдээс авч буй мэдээллийг хооронд нь харьцуулахуйц байлгахын тулд дизайны онцлогийг тайлагнах аргуудыг Хавсралт 2-т заасанчлан тодорхойлж өгөх нь зүйтэй.
- (iii) Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгч, импортлогч бүрээс тодорхой дизайны онцлогтой холбоотой хэмжилт хийсэн тухай лабораторийн тайлан, шинжилгээ хийсэн лаборатори нь магадлан итгэмжлэгдсэн гэх нотолгоог шаардаж авна.
- (iv) Тамхин бүтээгдэхүүний тодорхой брэндийн дизайны онцлог өөрчлөгдсөн даруйд тамхи үйлдвэрлэгчид төрийн эрх бүхий байгууллагад мэдэгдэж, мэдээллийг шинэчлэхийг Оролцогч талуудын зүгээс шаардана.

### 3.3.2 Журам

#### 3.3.2.1 Янжуур тамхи – Галын аюултай холбоотой журам (шатамхай чанарыг бууруулах)

##### (i) Суурь мэдээлэл

Харгалзахгүйгээр үлдээсэн асаасан тамхи шатаж, тавилга, ор дэрний хэрэгсэл, даавуу, бусад материалтай гал авалцах эрсдэлтэй. Энэхүү эрсдэл орондоо тамхи татах, согтуу, мансуурсан буюу эмийн нөлөөгөөр хариу урвал удааширсан үед тамхи татахад илүү өндөр байдаг. Янжуур тамхитай холбоотой гал гарснаас жил бүр цөөнгүй хүн гэмтэж, нас бардаг (түлэгдэлтээс буюу утаанд хордсоноос).

Янжуурыг сорохгүй үлдээсэн үед өөрөө унтардаг байхаар хийвэл гал авалцах эрсдэлийг бууруулж, гэмтэл, нас баралтаас сэргийлэх боломжтой юм. Ийм янжуур тамхийг шатамхай чанарыг нь бууруулсан янжуур гэдэг.

Зарим газар ердийн янжуурыг хорьж, зөвхөн шатамхай чанарыг нь бууруулсан янжуур борлуулахаар журамласнаар тамхины шалтгаант гал,

хохилогчдын тоо буурсан байна. Шатамхай чанарыг нь бууруулсан янжуур харгалзахгүйгээр үлдээсэн бүх тохиолдолд өөрөө унтардаггүй ч гал авалцах, улмаар гэмтэх, нас барах эрсдэлийг бууруулдаг. Шатамхай чанарыг нь бууруулсан янжуур борлуулахаар журамлах нь тамхитай холбоотой галын тоог бууруулах боловч бүрэн сэргийлж чадахгүйг цохон тэмдэглэх нь зүйтэй.

Шатамхай чанарыг нь бууруулсан янжуур тамхины хорт чанар ердийн янжууртай харьцуулахад өөр гэж зарим нь үздэг боловч судалгаанаас харахад эдгээрийн хорт чанар, хүний эрүүл мэндэд үзүүлэх хор нөлөө ялгаагүй байна.

(ii) Янжуур тамхины шатамхай чанартай холбоотой асуудлыг журамлах нь

Янжуур тамхины шатамхай чанартай холбоотой асуудлыг журамлахдаа төрийн эрх бүхий байгууллагууд гүйцэтгэлд тулгуурласан аргыг ашигладаг бөгөөд ингэхдээ шатамхай чанарыг шалгах арга, ямар тохиолдолд шалгуурыг давсан гэж үзэх (гүйцэтгэлийн стандарт)-ийг зааж өгөх нь зүйтэй (Хавсралт 4).

Цөөнгүй тохиолдолд төрийн эрх бүхий байгууллагууд янжуур тамхины шатамхай чанарыг бууруулах зураас бүхий цаас ашиглах зэрэг арга техниктэй холбоотой шаардлага, зөвшөөрөл олгоход тавих шаардлага зэргийг тогтоодог (Хавсралт 5).

(iii) Зөвлөмж

- i. Оролцогч талууд өөрийн орны онцлог, тэргүүлэх чиглэлд нийцүүлэн янжуур тамхи шатамхай чанарыг нь бууруулах стандартыг хангасан байх шаардлага тавина.
- ii. Дээрх i зөвлөмжийг хэрэгжүүлэхдээ Оролцогч талууд Хавсралт 4-д толилуулсан аргын дагуу шалгаж үзэхэд гүйцэд шатахгүй байгаа янжуур тамхины эзлэх хувийг тогтоосон олон улсын шаардлагад нийцсэн гүйцэтгэлийн стандарт тогтоох нь зүйтэй.
- iii. Оролцогч талууд шатамхай чанарыг нь бууруулсан янжуур тамхи гал авалцуулдаггүй гэсэн мессежийг хориглох ёстой.

### 3.3.2.2 Тамхин бүтээгдэхүүн – Анхаарал татахуйц байдалтай холбоотой журам

(i) Суурь мэдээлэл

Тамхи үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнийхээ дизайны онцлогийг өөрчлөх буюу шинэ дизайн нэвтрүүлэх замаар анхаарал татахуйц байдлыг нь сайжруулахад байнга анхаардаг. Тухайлбал, тамхи үйлдвэрлэгчид янжуур тамхины диаметрийг улам багасгасаар байна (нарийн, супер нарийн, ультра нарийн). Түүнчлэн янжуур тамхины шүүлтүүрт капсул хийж түүнийг нь хагалахад амт оруулагч ялгардаг байна.

Тамхи үйлдвэрлэгчид бүтээгдэхүүний дизайны онцлогийг ашиглан бүтээгдэхүүнээ нийгмийн өөр өөр бүлгүүдийн анхаарлыг татахуйц болгох стратеги буюу зах зээлийн сегментацийн аргыг ашигладаг. Нас, хүйс, гарал үүсэл, ёс заншил, нийгэм-эдийн засгийн байдал, эрүүл мэнддээ тавих анхаарал зэргээр нь нийгмийг бүлгүүд (сегментүүд)-эд хувааж болдог. Улмаар тамхи үйлдвэрлэгчид сегмент тус бүрийн сонирхол, имидж, хүсэл эрмэлзэл (турах, тансаг харагдах г.м), мэдрэхүйн онцлог зэрэгт нийцсэн дизайны онцлогтой бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд анхаардаг байна.

Тамхин бүтээгдэхүүний анхаарал татахуйц байдлыг бууруулах зорилгоор бүтээгдэхүүний дизайнтай холбоотой асуудлыг журамлах нь тамхины хэрэглээг бууруулахад нөлөөлж чаддаг.

(ii) Зөвлөмж

Оролцогч талууд 3.1.2.2-т заасанчлан тамхин бүтээгдэхүүний анхаарал татахуйц байдлыг бууруулахын тулд эдгээр бүтээгдэхүүний анхаарал татахуйц байдлыг нэмэгдүүлдэг дизайны онцлогийг журамлан зохицуулах шаардлагатай.

### **3.4 Төрийн эрх бүхий байгууллагуудад мэдээлэх нь – бусад мэдээлэл**

#### **3.4.1 Суурь мэдээлэл**

Бүтээгдэхүүн, түүний бүрэлдэхүүн хэсгийн зохицуулалтыг үр дүнтэй болгохын тулд төрийн эрх бүхий байгууллагууд зах зээлийн талаар үнэн зөв мэдээлэлтэй байх нь чухал юм. Эрх бүхий байгууллагууд зохицуулалтын хэрэгцээ, тэргүүлэх чиглэлээ тодорхойлохын тулд тухайн тамхин бүтээгдэхүүний бусадтай харьцуулахад ямар онцлогтой болохыг мэдэх шаардлагатай. Түүнчлэн ДЭМБ-ын ТХСК-ийн 20.2 дугаар зүйлд заасанчлан тамхины компани болон тэдгээрийн борлуулалтын талаарх мэдээлэл нь тамхины хэрэглээний цар хүрээ, хандлагыг үнэлэхэд тус дөхөм болно.

#### **3.4.2 Зөвлөмж**

Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгч, импортлогч нарт компанийн ерөнхий мэдээлэл, үүнд толгой компани болон үйлдвэрлэгч, импортлогч салбар болгоны нэр, хаяг, холбоо барих мэдээллийг гаргаж өгөх шаардлага тавина. Энэхүү мэдээлэл нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянахад ач холбогдолтой юм.

Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгч, импортлогч нарт борлуулалтын хэмжээ (ж.нь, янжуур тамхины тоо ширхэг, дүнсэн тамхины жин)-ний талаарх мэдээллийг тодорхой давтамжтайгаар брэнд тус бүрээр гаргаж өгч байх шаардлага тавина. Энэ нь үндэсний, шаардлагатай бол орон нутгийн түвшний мэдээлэл байна.

### **3.5 Олон нийтэд мэдээлэх нь**

#### **3.5.1 Суурь мэдээлэл**

Олон хүн тамхины хэрэглээ, тамхины утаанд өртсөнтэй холбоотой өвчлөл, цаг бус эндэгдлийн эрсдэлийг бүрэн ойлгодоггүй, дутуу үнэлдэг буюу энэ талаар ташаа ойлголттой байдаг. ДЭМБ-ын ТХСК-ийн 10 дугаар зүйлд тамхины эрэлтийг бууруулах бусад арга хэмжээний зэрэгцээ тамхин бүтээгдэхүүний найрлага дахь хорт бодис, ялгаруулах бодисын талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэх үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Оролцогч талуудаас шаарддаг. ДЭМБ-ын ТХСК-ийн 4.1 дүгээр зүйлд заасанчлан Оролцогч талууд тамхины хэрэглээ болон тамхины утаанд өртсөнтэй холбоотой эрүүл мэндийн үр дагавар, үхлийн аюул, тамхины донтуулах чанарын талаарх мэдээллийг хүн бүрт хүргэх зарчмыг удирдлага болгох шаардлагатай.

### 3.5.2 Олон нийтэд мэдээлэх арга, хамрах хүрээ

#### 3.5.2.1 Төрийн эрх бүхий байгууллагуудад гаргаж өгсөн мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй болгох нь

Тамхин бүтээгдэхүүний найрлага дахь хорт бодис, түүнээс ялгарах бодисын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг мэргэжлийн бус хүн ойлгоход төвөгтэй, ийм мэдээллийг олон нийтэд ил болгох нь нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах шууд үр нөлөөгүй байж болно. Гэхдээ ийм төрлийн мэдээлэл нь иргэний нийгмийн бусад гишүүд, нэн ялангуяа судалгааны байгууллага, ТББ-уудад тамхины хяналтын бодлого боловсруулахад хувь нэмрээ оруулах боломжийг олгож болно.

Түүнчлэн энэхүү удирдамжийн дагуу эрх бүхий байгууллагуудад гаргаж өгсөн бусад мэдээлэл, тухайлбал тамхин бүтээгдэхүүний бүрэлдэхүүн хэсэг, шинж чанар, зах зээлийн талаарх мэдээлэл нь олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, тамхины хяналтын бодлогыг сайжруулахад хувь нэмэр оруулах ач холбогдолтой.

#### *Зөвлөмж:*

Оролцогч талууд энэхүү удирдамжийн дагуу төрийн эрх бүхий байгууллагуудад мэдээлсэн тамхин бүтээгдэхүүний найрлага дахь хорт бодис, ялгаруулах бодисын талаарх болон бусад мэдээллийг үндэсний хууль тогтоомждоо нийцүүлэн олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр (ж.нь, интернэтээр, эрх бүхий байгууллагад гаргасан хүсэлтийг үндэслэн) ил болгох асуудлыг авч үзнэ.

#### 3.5.2.2 ДЭМБ-ын ТХСК-ийн 11 ба 12 дугаар зүйлийн дагуу тамхин бүтээгдэхүүний найрлага дахь бодис, ялгаруулах бодисын талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэх нь

Олон нийтэд мэдээлэх асуудал ДЭМБ-ын ТХСК-ийн 11 ба 12 дугаар зүйлтэй хэрхэн холбогдох тухай мэдээллийг “ДЭМБ-ын ТХСК-ийн бусад зүйлтэй холбогдох нь” хэмээх 7 дугаар хэсгээс харна уу.

## **4. ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БА ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАХ НЬ**

### **4.1 Цогц арга**

Хууль эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг үр дүнтэй байлгахын тулд тамхи үйлдвэрлэгч, импортлогч нарыг тэдгээрийг хэрэгжүүлэхээр үүрэгжүүлж, зөрчил гаргасан тохиолдолд шийтгэл ногдуулах шаардлагатай. Үүний тулд эдгээрийн хэрэгжилтийг хангах, хянах эрх бүхий байгууллагуудыг тодорхой зааж, хэрэгжилтийг хянах ба зөрчилд шийтгэл ногдуулах тогтолцоог бүрдүүлэх хэрэгтэй..

### **4.2 Дэд бүтэц ба төсөв**

Оролцогч талууд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах, хангах дэд бүтцийг бүрдүүлэх ёстой. Мөн эдгээр үйл ажиллагаанд зориулж төсвийн санхүүжилт олгох шаардлагатай.



### **4.3 Стратеги**

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулахын тулд хууль тогтоомжоор тавьж буй шаардлагуудын талаар тэдгээрийг хэрэгжиж хэлэхээс өмнө сонирхогч талуудад мэдээлэх нь зүйтэй.

Оролцогч талууд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор тамхи үйлдвэрлэх, импортлох, борлуулах цэгүүдэд тогтмол хяналт тавихад байцаагч, хууль хэрэгжүүлэх байгууллагуудыг татан оролцуулах нь зүйтэй. Өргөжүүлэх боломжтой хяналтын механизм байгаа нөхцөлд шинээр хяналтын тогтолцоо бүрдүүлэх шаардлагагүй.

### **4.4 Хэрэгжүүлэх эцсийн хугацаа**

#### **4.4.1 Хориглосон буюу хязгаарласан бүрэлдэхүүн хэсэг**

Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгчид, борлуулагчид зөвхөн шаардлага хангасан тамхин бүтээгдэхүүн нийлүүлж эхлэх эцсийн хугацааг тодорхой заана.

#### **4.4.2 Шатамхай чанарыг бууруулах арга хэмжээ**

Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгчид, борлуулагчид зөвхөн шатамхай чанарыг бууруулах стандартад нийцсэн янжуур тамхи нийлүүлж эхлэх эцсийн хугацааг тодорхой заана.

### **4.5 Хяналт – хориглосон буюу хязгаарласан бүрэлдэхүүн хэсэг**

Оролцогч талууд хориглосон буюу хязгаарласан бүрэлдэхүүн хэсгийг ашиглаж байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор үйлдвэрийн газарт очиж, газар дээр нь хяналт тавих шаардлагатай. Хяналтын хүрээнд түүхий эд болон бэлэн бүтээгдэхүүн хадгалах агуулахад шалгалт хийхийн сацуу үйлдвэрлэлийн үйл явцад шууд ажиглалт хийнэ. Хяналт нь тамхин бүтээгдэхүүнд зөвшөөрөл буюу гэрчилгээ олгох, үйлдвэрлэлийн үйл явцыг хүлээн зөвшөөрөх үйл ажиллагаа биш юм.

### **4.6 Дээж авах ба шинжилгээ хийх**

#### **4.6.1 Хориглосон буюу хязгаарласан бүрэлдэхүүн хэсэг**

Оролцогч талууд импортлогчийн байр сав, борлуулалтын цэг, шаардлагатай бол үйлдвэрийн газраас тамхин бүтээгдэхүүний дээж цуглуулна. Цуглуулсан дээжинд хориглосон буюу хязгаарласан бүрэлдэхүүн хэсэг байгаа эсэхийг хяналтын лабораторид шинжилж, шалгана (Хавсралт 3).

#### **4.6.2 Шатамхай чанарыг бууруулах арга хэмжээ**

Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгч, импортлогч, борлуулагч нараас янжуур тамхины дээж цуглуулж, эдгээр нь шатамхай чанарыг нь бууруулсан янжуур тамхины стандартад нийцэж байгаа эсэхийг шинжилж тогтооно. Ингэхдээ Хавсралт 4-д заасан аргачлалын дагуу дээж цуглуулж, шинжилгээ хийнэ.

#### **4.7 Төрийн эрх бүхий байгууллагуудад мэдээлсний дараах аудит**

Оролцогч талууд тамхины үйлдвэрийн газруудад аудит хийж, тамхин бүтээгдэхүүний талаар гаргаж өгсөн мэдээлэл нь бүрэн гүйцэд, үнэн зөв эсэхийг баталгаажуулна. Аудит нь тамхин бүтээгдэхүүнд зөвшөөрөл буюу гэрчилгээ олгох, үйлдвэрлэлийн үйл явцыг хүлээн зөвшөөрөх үйл ажиллагаа биш юм.

#### **4.8 Хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээ**

Оролцогч талууд хяналтын байгууллагуудын зөрчил илэрсэн үед шуурхай, шийдвэртэй арга хэмжээ авах бэлэн байдлыг хангахад анхаарна. Зөрчил гарсан үед цаг алдалгүй шийдвэртэй арга хэмжээ авснаар хууль тогтоомжийг биелүүлэх шаардлага хүчтэй тавигдаж байгааг ойлгуулж, цаашид хэрэгжилтийг хангахад тус дөхөм болдог. Оролцогч талууд хяналтын үр дүнг олон нийтэд нээлттэй мэдээлэх, зөрчлийг илрүүлж, холбогдох арга хэмжээ авч байгаа талаар мессеж өгөх нь зүйтэй.

#### **4.9 Хуулийн хариуцлага**

Оролцогч талууд зөрчлөөс сэргийлэхийн тулд хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй нөхцөлд эрүүгийн хариуцлага, мөнгөн торгууль ногдуулах, залруулах арга хэмжээ авах, үйл ажиллагааны болон импортын тусгай зөвшөөрлийг хязгаарлах буюу цуцлах зэрэг хуулийн дагуу хүлээх хариуцлагыг тодорхой зааж өгөх шаардлагатай.

#### **4.10 Хураах, битүүмжлэх, устгах арга хэмжээ**

Оролцогч талууд хууль тогтоомжид нийцээгүй тамхин бүтээгдэхүүнийг үндэсний хууль тогтоомжийн дагуу хяналтан дор хураах, битүүмжлэх, устгах эрх мэдэлтэй байна.

#### **4.11 Шийтгэл**

Оролцогч талууд зөрчлийн шинж чанар, давтамжид нийцсэн байдлаар торгуулийн болон шийтгэлийн бусад арга хэмжээг тодорхойлох шаардлагатай.

### **5. ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА**

Тамхин бүтээгдэхүүний асуудлыг журамлах, мэдээлэх чиглэлээр ахиц дэвшил гаргахад олон улсын хамтын ажиллагаа амин чухал юм. ДЭМБ-ын ТХСК-ийн хэд хэдэн зүйл заалтад хэрэгжилтийг дэмжихийн тулд мэдлэг, туршлага солилцох талаар туссан байна. ДЭМБ-ын ТХСК-ийн 22 дугаар зүйлд заасанчлан энэхүү хамтын ажиллагаа нь талуудын харилцан тохиролцсоны дагуу мэргэжлийн, шинжлэх ухааны болон эрх зүйн туршлага, технологийн солилцоог хөхиүлэн дэмжихэд чиглэнэ. Үүний үр дүнд энэхүү удирдамжийг үр дүнтэй хэрэгжүүлж, тамхин бүтээгдэхүүний орц найрлагыг зохицуулах шилдэг арга замыг боловсруулах боломжтой болно.

## **6. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ БА ҮНЭЛГЭЭ**

(Энэхүү хэсгийг дараа дараагийн удирдамжуудад тодорхой тусгахаар хоосон орхисон болно.)

## **7. ДЭМБ-ЫН ТХСК-ИЙН БУСАД ЗҮЙЛТЭЙ ХОЛБОГДОХ НЬ**

### **7.1 Хориглосон бүрэлдэхүүн хэсэг байгааг илэрхийлсэн сав, баглаа, боодол**

ДЭМБ-ын ТХСК-ийн 11 ба 13 дугаар зүйлд заасанчлан тамхин бүтээгдэхүүний сав, баглаа, боодол дээр аливаа төрлийн зар сурталчилгааг хориглох арга хэмжээ (11 ба 13 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамжид толилуулсан ёсоор) авч хэрэгжүүлснээс бусад тохиолдолд Оролцогч талууд энэхүү удирдамжийн дагуу хориглосон буюу хязгаарласан бүрэлдэхүүн хэсэг агуулсан болохыг илэрхийлсэн сав, баглаа, боодолтой тамхин бүтээгдэхүүнийг борлуулахыг хориглох шаардлагатай.

### **7.2 Найрлага дахь бодис болон ялгаруулах бодисын тухай тамхины сав, баглаа, боодол дээрх мэдээлэл**

ДЭМБ-ын ТХСК-ийн 11 дүгээр зүйлд заасанчлан тамхин бүтээгдэхүүний сав, баглаа, боодол, шошгололт нь найрлага дахь бодис болон ялгаруулах бодисын тухай мэдээллийг олон нийтэд хүргэх үр дүнтэй арга хэрэгсэл болдог.

Оролцогч талууд энэ асуудлаар Конвенцийн 11 дүгээр зүйл болон түүнийг хэрэгжүүлэх удирдамжийг харна уу.

### **7.3 Найрлага дахь бодис болон ялгаруулах бодисын тухай мэдээллийг сургалт сурталчилгаа, олон нийтэд боловсрол олгох хөтөлбөрүүдэд ашиглах нь**

Оролцогч талууд тамхин бүтээгдэхүүний найрлага дахь бодис болон ялгаруулах бодисын тухай мэдээллийг сургалт сурталчилгаа, олон нийтэд боловсрол олгох хөтөлбөрүүдэд ашиглах нь зүйтэй. Энэхүү мэдээлэл нь ДЭМБ-ын ТХСК-ийн 12 дугаар зүйл, түүнийг хэрэгжүүлэх удирдамжийн дагуу явуулах сургалт сурталчилгаа, боловсролын хөтөлбөрийн хүрээнд олон нийтэд тамхины хэрэглээ, тамхины утаанд өртсөнтэй холбоотой хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, донтуулах чанар, үхлийн аюулын талаар мэдээлэл хүргэх үйл ажиллагаанд тус дөхөм болно.

## ХАВСРАЛТ 1

### *Тамхин бүтээгдэхүүний зохицуулалтын арга хэмжээг санхүүжүүлэх аргуудын тайлбар бүхий жишээ*

(a) Тамхины тусгайлсан татвар

Тамхины тусгайлсан татвар ногдуулах зорилго нь тамхины татварын орлогын тодорхой хувийг тамхины хяналтын хөтөлбөр буюу эрүүл мэндийг дэмжих сан зэрэг тодорхой хэрэгцээнд зориулахад оршдог. Ийнхүү зориулах татварын орлогын хэмжээг орлогын хувь (ж.нь, 1%) эсхүл нэгжид ногдох мөнгөн дүн (20 ширхэг янжуур тамхи тутамд 25 цент)-ээр илэрхийлж болно.

(b) Тамхины үйлдвэрлэл ба/буюу импортын тусгай зөвшөөрлийн хураамж

Тамхи үйлдвэрлэл, импортын тусгай зөвшөөрлийн хураамжийг хэд хэдэн арга замаар ногдуулж болно. Хураамжийн хэмжээг компанийн том жижгээс үл хамаарч нэг компанид ногдох тодорхой мөнгөн дүнгээр тогтоож болно (Ингэхдээ үйлдвэрлэл, импортын үйл ажиллагаа эрхлэх нэгж тус бүрээс нэмэлт хураамж авч болно). Эсхүл хураамжийн хэмжээг борлуулсан нэгж бүтээгдэхүүнд ногдох мөнгөн дүнгээр тогтоож болно (ж.нь, нэг янжуур буюу боодол янжуур тутам, зарим тамхин бүтээгдэхүүний грамм тутам ногдуулах). Эсхүл бүх компанид ногдох хураамжийн нийт хэмжээг тогтоож, улмаар тухайн компанийн зах зээлд эзлэх хувь хэмжээнд тохируулж түүний төлөх хураамжийг тодорхойлж болно (ж.нь, бүх компанид ногдох хураамжийн нийт хэмжээг 100 сая ам.доллар гэж тогтоосон бол зах зээлийн 20%-ийг эзэлдэг компанийн тусгай зөвшөөрлийн хураамж 20 сая ам.доллар байна гэсэн үг). Хураамжийг төлөх хугацааг “санхүүгийн жил эхлэхийн өмнө” гэх зэргээр тодорхой зааж болно. Хэрэв хураамжийг борлуулсан нэгж бүтээгдэхүүнд ногдох мөнгөн дүнгээр тогтоосон бол хураамж төлөлтийг “сар тутам” гэх зэргээр арай ойр ойрхон давтамжтайгаар тогтоож болно.

(c) Тамхин бүтээгдэхүүний бүртгэлийн хураамж

Тамхи үйлдвэрлэгч, импортлогч, бөөний дистрибьютер зэргээс тухайн компанийн борлуулж буй тамхин бүтээгдэхүүн болгоныг бүртгүүлж, холбогдох хураамж төлөхийг шаардаж болно. Бүтээгдэхүүнд шинжилгээ, хэмжилт хийх, хяналт тавих зэрэгт төрөөс зарцуулж буй зардлыг бүрэн буюу хэсэгчлэн нөхөхүйц түвшинд хураамжийн хэмжээг тогтоож болно. Хураамжийг төлөх хугацааг “санхүүгийн жил эхлэхийн өмнө” гэх зэргээр тодорхой зааж болно.

(d) Тамхины дистрибьютер ба/буюу борлуулагчдад тусгай зөвшөөрөл олгох

Дистрибьютер буюу борлуулагч, эсхүл аль алинаас нь тусгай зөвшөөрлийн хураамж авч болно. Хураамжийн хэмжээг компанийн том жижгээс үл хамаарч нэг компанид ногдох тодорхой мөнгөн дүнгээр тогтоож болно (Ингэхдээ үйлдвэрлэл, импортын үйл ажиллагаа эрхлэх нэгж тус бүрээс нэмэлт хураамж авч болно). Эсхүл дистрибьютер, борлуулагчийн хэмжээ (ж.нь, борлуулалтын хэмжээ)-ээс хамаарч хураамжийг ялгавартайгаар тогтоож болно. Хураамжийн хэмжээг борлуулалтын хэмжээ (борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ эсхүл

орлогын мөнгөн дүн)-ээс хамаарч ялгавартайгаар тогтоож болно, тухайлбал борлуулалтын хэмжээ “А” хүртэл байвал суурь хураамж, хэрэв “А”-аас “Б”-ийн хооронд байвал нэмэгдүүлсэн хураамж, “Б”-ээс их байвал илүү өндөр хураамж. Хураамжийг төлөх хугацааг “санхүүгийн жил эхлэхийн өмнө” гэх зэргээр тодорхой зааж болно.

(e) Хууль тогтоомж зөрчсөн тамхи үйлдвэрлэгч, импортлогч нарт торгууль ногдуулах

Захиргааны зөрчилд торгууль ногдуулж орлого бүрдүүлж болно. Хувь хүн, хуулийн этгээд хууль бус үйл ажиллагаа явуулснаар учруулсан хохирлыг барагдуулахын тулд захиргааны байгууллагаас зөрчил гаргасан этгээдэд торгууль ногдуулж болно. Түүнчлэн шүүхийн шийдвэрээр торгууль ногдуулж орлого бүрдүүлж болно.

(f) Жил тутам хийх тамхины тандалтын төлбөр (тамхи үйлдвэрлэгч, борлуулагч нарт ногдуулах)

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хянах зардлыг тамхи үйлдвэрлэгч, борлуулагч нараас тамхины тандалтын төлбөр хэлбэрээр жил тутам гаргуулж болно. Тамхи үйлдвэрлэгч/импортлогч/дистрибьютерийн хувьд төлбөрийн хэмжээг нэг компанид ногдох тогтсон хэмжээ хэлбэрээр тогтоохоос гадна борлуулсан брэнд тус бүрт ногдох тогтсон хэмжээ хэлбэрээр эсхүл борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, зах зээлд эзлэх хувь хэмжээнээс хамааруулж тогтоож болно. Харин тамхины жижиглэн худалдаа эрхлэгч нарын хувьд борлуулалтын цэг тус бүрээс тусгай зөвшөөрлийн болон тандалтын төлбөр авах шаардлагатай байж болно.

## ХАВСРАЛТ 2

### Янжуур тамхины дизайны онцлог<sup>11</sup>

- (a) Хэмжээ, диаметр, жин
- (b) Шүүлтүүрийн урт, шүүлтүүрийн хөндлөн огтлолын хэлбэр
- (c) Соруулын цаасны урт
- (d) Янжуур тамхины ишний хөндлөн огтлолын хэмжээ, хэлбэр
- (e) Төгсгөлийн тэмдэглэлээс агааржуулалтын нүх хүртэлх зай, миллиметрээр
- (f) ISO 6565 (Тамхи ба тамхин бүтээгдэхүүн - Янжуур тамхийг сороход учрах эсэргүүцэл ба шүүлтүүрийн даралтын уналт - Стандарт нөхцөл ба хэмжилт) стандартын дагуу хэмжсэн янжуур тамхийг сороход учрах эсэргүүцэл
- (g) ISO 9512 (Янжуур тамхи - Агааржуулалтыг тодорхойлох - Тодорхойлолт ба хэмжилт хийх зарчим) стандартын дагуу хэмжсэн шүүлтүүрийн агааржуулалтын хэмжээ
- (h) ISO 9512 (Янжуур тамхи - Агааржуулалтыг тодорхойлох - Тодорхойлолт ба хэмжилт хийх зарчим) стандартын дагуу хэмжсэн цаасны агааржуулалтын хэмжээ
- (i) ISO 2965 (Янжуур тамхины цаас, шүүлтүүрийг ороох ба холбох цаас зэрэг материал - Агаар нэвчүүлэх чанарыг тодорхойлох) стандартын дагуу тодорхойлсон янжуур тамхины цаасны төрөл ба түүний агаар нэвчүүлэх чанар
- (j) Бүтээгдэхүүний нягт чанар (боодлын нягтралын хэмжээс)
- (k) ISO 6565 (Тамхи ба тамхин бүтээгдэхүүн - Янжуур тамхийг сороход учрах эсэргүүцэл ба шүүлтүүрийн даралтын уналт - Стандарт нөхцөл ба хэмжилт) стандартын дагуу хэмжсэн шүүлтүүрийн даралтын уналт
- (l) Аналитик химич нарын албан ёсны нийгэмлэгийн Албан ёсны арга 966.02 (тамхийг хатаахад явагдах чийгний алдагдал)<sup>12</sup>-ийн дагуу тодорхойлсон чийгний орц найрлага
- (m) Шүүлтүүрний төрөл (ж.нь, целлюлозын ацетат) ба бусад шинж чанар (ж.нь, үнсний орц найрлага)
- (n) Янжуур тамхинд нэмэлтээр хэрэглэсэн шинэлэг бүрэлдэхүүн хэсгүүд (ж.нь, капсул)-ийн тайлбар

<sup>11</sup> Энд хэрэглэсэн нэр томъёоны тайлбарыг ISO 9512 (Янжуур тамхи - Агааржуулалтыг тодорхойлох - Тодорхойлолт ба хэмжилт хийх зарчим) стандартаас харна уу.

<sup>12</sup> Horwitz W, Latimer G, eds. Official methods of analysis, 18<sup>th</sup> ed., Revision 3. Gaithersburg, MD, AOAC International, 2010

### ХАВСРАЛТ 3

#### *Бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлох шинжилгээний аргууд*

- (a) Хууль тогтоомжийн хяналтын хүрээнд хориглосон буюу хязгаарласан бүрэлдэхүүн хэсэг байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор шинжилгээ хийх шаардлага гарч болно. Энэ нь дээж авах, дээжинд боловсруулалт хийх, ялгах, тодорхойлох, хэмжих, тоо мэдээнд дүн шинжилгээ хийх зэрэг үе шаттайгаар хийгдэнэ.
- (b) Шинжилгээг тусгайлан сургагдсан мэргэжилтэн зохих ёсоор тоноглогдсон лабораторид хийж гүйцэтгэнэ. Шинжилгээнд аюултай материал ашиглах шаардлага гардаг. Шинжилгээг аюулгүй, зөв хийхийн тулд лабораторийн ажилтнууд аюултай материалтай харьцах аюулгүй ажиллагааны стандартыг мөрдөх шаардлагатай.
- (c) Хүнсний нэмэлтийг тамхин бүтээгдэхүүний бүрэлдэхүүн хэсэг болгон ашигласан тохиолдолд тохирох шинжилгээний аргын талаар дэлгэрэнгүйг *Хүнсний нэмэлтийн шинж чанарын эмхэтгэл (4-р боть)*<sup>13</sup>-ээс харна уу. Энэхүү баримт бичиг нь хүнс буюу хүнсний үйлдвэрлэлд ашигладаг нэмэлтүүдийг тодорхойлох шинжилгээний аргуудын гарын авлага юм.
- (d) Амт оруулагч зэрэг буцлах хэм багатай (ө.х, нам температурт амархан ууршдаг) бүрэлдэхүүн хэсгүүдийн хувьд хийн хроматографийн тусгай аргыг ашигладаг бөгөөд энэхүү аргын талаар дэлгэрэнгүйг *Хүнсний нэмэлтийн шинж чанарын эмхэтгэл (4-р боть)*-ээс харна уу.
- (e) Буцлах хэм багатай бүрэлдэхүүн хэсгийн дээж авах, ялгах, тодорхойлох, хэмжихэд хийн хроматографийн/масс спектометрийн аргын хамт “хатуу фазын бичил экстракци”<sup>14</sup>-ийг ашиглаж болно.

---

<sup>13</sup> Joint FAO/WHO Expert Committee on Food Additives. Combined compendium of food additive specifications. Volume 4: analytical methods, test procedures and laboratory solutions used by and referenced in the food additive specifications. Rome, Food and Agriculture Organization of the United Nations, 2006 (FAO JECFA Monograph No. 1) (<http://www.fao.org/docrep/009/a0691e/A0691E00.htm>).

<sup>14</sup> Pawliszyn J et al. Solid-phase microextraction (SPME). The chemical educator, 1997, 2(4):1–7 (<http://www.springerlink.com/content/h72xx3624q122085/fulltext.pdf>).

## ХАВСРАЛТ 4

### *Шатамхай чанарыг нь бууруулсан янжуур тамхины гүйцэтгэлийн чанар ба шинжилгээний стандарт аргууд*

Шатамхай чанарыг нь бууруулсан янжуур тамхины гүйцэтгэлийн стандартыг “асааж, урьдчилан тогтсон бодис дээр тавихад дуустлаа шатаагүй янжуур тамхины хувь”-иар илэрхийлдэг.

2012 оны байдлаар олон улсад энэ стандартыг 75%-иас багагүй байна гэж тогтоосон байна.

2012 оны байдлаар дээрх гүйцэтгэлийн стандартын хэрэгжилтийг баталгаажуулах шинжилгээний дараах стандарт аргууд байна. Үүнд: ISO 12863:2010 “Янжуур тамхины шатамхай чанарыг үнэлэх шинжилгээний стандарт арга”; EN ISO 12863:2010 “Янжуур тамхины шатамхай чанарыг үнэлэх шинжилгээний стандарт арга”; AS 4830-2007 “Янжуур тамхины унтрах хандлагыг тодорхойлох нь”; NZS/AS 4830:2007 “Янжуур тамхины унтрах хандлагыг тодорхойлох нь”; ASTM E2187-09 “Янжуур тамхины шатах чадлыг хэмжих шинжилгээний стандарт арга”.

## ХАВСРАЛТ 5

### *Шатамхай чанарыг нь бууруулсан янжуур тамхи - нэмэлт мэдээлэл*

#### (a) Янжуур тамхины цаасны дизайн

Оролцогч талууд зураас бүхий цаас ашиглах шаардлага тавьдаг бол янжуур тамхийг ороосон нэг зураас нь янжуур тамхийг асаадаг үзүүрээс 15 мм-ээс доошгүй зайд, харин хоёрдох зураас нь шүүлтүүрийн төгсгөлөөс 15 мм-ээс доошгүй эсхүл шүүлтүүргүй янжуурны хувьд тамхины баганын төгсгөлийг тэмдэглэсэн тэмдэглэгээнээс 10 мм-ээс доошгүй зайд байрлах ёстой.

#### (b) Зөвшөөрөл олгоход тавих шаардлага

Зөвшөөрөл авах үйл ажиллагааг сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлдэг тохиолдолд тамхи үйлдвэрлэгч төрийн эрх бүхий байгууллагад бүтээгдэхүүн нь шатамхай чанарыг нь бууруулсан янжуур тамхины гүйцэтгэлийн стандартыг хангаж байгаа талаар мэдэгдэл гаргаж өгнө. Эсхүл заавал зөвшөөрөл авах шаардлага тавьж, гуравдагч этгээдээр шалгуулж зөвшөөрөл олгож болно.

-oOo-